

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

**1. Биеийн тамир, спортын тхуай хуулийн шинэчилсэн
найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн
төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн
мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 3-5

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
05 дугаар сарын 30-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Б.Баярсайхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 38 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, П.Анужин, Ё.Баатарбилэг, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Ч.Ундрам, Л.Энх-Амгалан.

Нэг.Биеийн тамир, спортын тхуай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга Э.Тэмүүжин, мөн албаны хуульч Б.Өлзийбаяр, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, Биеийн тамир, спортын салбарын судлаач Х.Бакытжан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Б.Баярсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн “13.1.11” дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 13.1.6 дахь заалтын “санхүүгийн дэмжлэгийг төсөвт тусган санхүүжүүлэх” гэснийг “олгосон санхүүжилтийг зарцуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.1.7, 13.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.7.орон нутгийн төсвөөс өсвөр үе, оюутны шигшээ багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

13.1.10.нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогийг харгалзан спортын төрлийг хөгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн тавьсан асуултад Биеийн тамир, спортын салбарын судлаач Х.Бакытжан, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны хуульч Б.Өлзийбаяр нар хариулж, тайлбар хийв.

Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 38 минут

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Баярсайхан: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны эрхэм гишүүд та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Байнгын хорооны хуралдаан эхэлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны ирцийг танилцуулъя. Ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн ирсэн. Ирц бүрдсэн тул хурлаа эхэлье. Ирц танилцуулъя. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд Балжиннямын Баярсайхан Завхан 9 дүгээр тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн ирсэн байна. Баян-Өлгий аймаг 2 дугаар тойргоос сонгогдсон Телеуханы Аубакир гишүүн ирсэн байна. Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар тойргоос сонгогдсон Энхбаярын Батиугар гишүүн ирсэн байна. Сонгинохайрхан дүүрэг 27 дугаар тойргоос сонгогдсон Бадарчийн Жаргалмаа гишүүн ирсэн байна. Дундговь, Говьсүмбэр аймаг 6 дугаар тойргоос сонгогдсон Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Сүхбаатар дүүргийн 24 дүгээр тойргоос сонгогдсон Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар тойргоос сонгогдсон Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байна. Баянзүрх дүүрэг 23 дугаар тойргоос сонгогдсон Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Өвөрхангай аймаг 10 дугаар тойргоос сонгогдсон Содномын Чинзориг гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэнэ.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудын нэрсийг бас танилцуулъя.

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамирын спортын үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд хүрэлцэн ирсэн байна. Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга Эрдэнийн Тэмүүжин хүрэлцэн ирсэн байна. Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Осорын Баттулга хүрэлцэн ирсэн байна. Биеийн тамир спортын салбарын судлаач Халимханы Бакытжан хүрэлцэн ирсэн байна. Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны хуульч Баярсайханы Өлзийбаяр нар хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал. Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу Улсын Их Хурлын даргаас

гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 1 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 1 саналаар санал хураалт явуулъя.

Чинбүрэн гишүүнд микрофон өгье.

Ж.Чинбүрэн: Би яг энэ зүйл, заалттай холбоотой биш нэг өөр асуулт асуух гээд ажлын хэсгээс. Тэгэхээр бид нөгөө ажлын дэд хэсэг дээр ярьж байсан чухал зүйл бол нөгөө Допингийн үндэсний зөвлөлийн асуудлыг ярьсан тийм ээ. Тэгээд тэр дээр та бүхэн бас яг нөгөө олон улсын Вада-гийн зарчмыг барихгүй бол бид бас болдоггүй юм гэж хэлж байсан. Миний тавьж байсан санал бол хугацаа зааж байсан. Хугацаатай байх уу гээд. Тэгээд энэ яг ямар байдлаар орж байгаа вэ. Би бол юу гэж хэлэх гээд байгаа гэхээр нөгөө Бат-Эрдэнэ аварга түрүүн хэлсэн нөгөө олон улсын зарчмаараа явах ёстой юм байна лээ шүү гэсэн. Тэгээд тэр нь яг мөрдөгдөж байгаа биз. Бид одоо буруу зөрүү юм болчихоогүй биз ээ гэж л асуух гээд байгаа юм. Энэ дээр нэг хариулт авчихмаар байгаа юм. Нөгөө Допингийн үндэсний зөвлөлтэй холбоотой.

Б.Баярсайхан: Ажлын хэсгээс хариулъя. 1 номерын микрофоныг өгье. Чинбүрэн гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя.

Х.Бакытжан: Ажлын хэсгийн гишүүн Х.Бакытжан. Дэлхийн допингийн эсрэг агентлагийн дүрэм дээр Допингийн эсрэг үндэсний байгууллагын үйл ажиллагаа, шийдвэрт спортын бусад байгууллага болон төрийн байгууллага хөндлөнгөөс оролцохыг бол хязгаарласан байдаг.

Б.Баярсайхан: Гишүүний асуултад бүрэн хариулъя. Хэн хариулах вэ. Ажлын хэсгээс. 2 номерын микрофон өгье.

Б.Өлзийбаяр: Ажлын хэсгийн дэд хэсгийн гишүүн Өлзийбаяр байна.

Хуулийн төсөлд орсноор бол Допингийн эсрэг үндэсний байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн 3 жилд 1 удаа сонгогдоно гэсэн нэр орсон байгаа.

Б.Баярсайхан: Чинбүрэн гишүүн тодруулах уу.

Ж.Чинбүрэн: Зөв байгаа юу л гэж асууж байгаа байхгүй юу. Тэгэхээр миний асууж байгаа санаа бол олон улсын дүрэм, журамтайгаа тэнцэж байгаа юу. Тэнцэхгүй байгаа юу. Хэрвээ тэнцэхгүй байгаа бол нөгөө олон улсын журамд нь тааруулахгүй бол та хэд чинь уначихна шүү дээ. Энэ хууль чинь өөрөө нөгөө олон улсын допингийн холбооныхоо журмыг бид барьж энэ хуулийн төсөлдөө оруулж чадсан уу эсвэл нөгөөх нь бүр буруу тийшээ эргэчихсэн үү л гэж асуугаад байгаа юм.

Б.Баярсайхан: Энэ маш чухал асуулт асуугаад байна. Яг тодорхой хариул даа ажлын хэсэг. Энэ чухал асуулт асуугаад байна. Ерөөсөө манай энэ хуулийн бас амин чухал хэсгийн нэг чинь энэ байгаад байгаа шүү дээ. Ажлын хэсэг хариулъя 2 номер.

Б.Өлзийбаяр: Монгол Улс 2007 онд нэгдэж орсон Сэргээшний эсрэг конвенц байгаа. Конвенцын 4-д бол тухайн улс өөрийн хууль, тогтоомжоор допингийн эсрэг үйл ажиллагааг хуульчлах бүрэн эрх байгаа.

Б.Баярсайхан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу санал хураалгая. Энэ саналыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 13 дугаар зүйлийн “13.1.11” дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 13.1.6 дахь заалтын “санхүүгийн дэмжлэгийг төсөвт тусган санхүүжүүлэх” гэснийг “олгосон санхүүжилтийг зарцуулах” гэж

өөрчилж, мөн зүйлийн 13.1.7, 13.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.7.орон нутгийн төсвөөс өсвөр үе, оюутны шигшээ багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

13.1.10.нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогийг харгалзан спортын төрлийг хөгжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Цэрэнжамцын Мөнхцэцэг уншиж танилцуулна. Та бүхэндээ хуралдаа идэвхтэй оролцсонд баярлалаа.

12.48 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ